

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

**СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Сонгуулийн тухай хуулийн 125 зүйлийн 4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 125.4.6, 125.4.7 дахь заалт нэмсүгэй:

“125.4.6. Нэр дэвшигч нь оффшор бүсэд өөрийн болон хамаарал бүхий хүний нэр дээр банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулаагүй, архи тамхи, согтууруулах ундааны зүйлийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжтэй ямар нэгэн байдлаар хамааралгүй, ашигт малтмалын лиценз эзэмшдэггүй байх.

125.4.7. Нэр дэвшигч нь урьд нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, төрийн өмч болон төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, хахууль өгөх, авах гэмт хэрэгт холбогдож ял шийтгүүлж байгаагүй байх.”

**2 дугаар зүйл.** Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.4.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“125.4.4. Нэр дэвшигч нь нэр дэвших үед эрүүгийн хэрэг үүсгэж, прокурорын байгууллагаас яллах дүгнэлт үйлдэгдээгүй, шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх.”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2019 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг